



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 сарын 22-ны өдрийн 19 дүгээр албан даалгавар, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/32 тоот тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/108 тоот захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/07 тоот тушаал, Нийслэлийн онцгой комиссын 02 дугаар хурлын тэмдэглэл, Эрүүл мэндийн төвийн даргын А/14 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Өлзийт 1 айдсын даваа" авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтний мөрдөх түр журмыг нэгдүгээр хавсралтаар, асуумжийн маягыг хоёрдугаар хавсралтаар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааны үлгэрчилсэн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга/Б.Лувсаннямд/үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн Даргын
2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
#16 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“ӨЛЗИЙТ 1 АЙДСЫН ДАВАА” АВТО ТЭЭВРИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ
ТОВЧООНД АЖИЛЛАХ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖИЛЛАХ ТҮР
ЖУРАМ**

Нэг. Үндэслэл

1. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 сарын 22-ны өдрийн 19 дүгээр албан даалгавар, Эрүүл Мэндийн сайдын 2020 оны А/32 тоот тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/108 тоот захирамж, Нийслэлийн онцгой комиссын 02 дугаар хурлын тэмдэглэл, Эрүүл мэндийн төвийн даргын А/14 тоот тушаалыг тус тус үндэслэн “Өлзийт 1 айдсын даваа” авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд шинэ коронавирусын халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт, халдваргүйтгэл хийх үйл ажиллагааг энэхүү түр журмаар зохицуулна.
2. “Өлзийт 1 айдсын даваа” авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд ажиллаж байгаа эмч эмнэлгийн мэргэжилтэн Эрүүл мэндийн сайдын 2015 оны “Хүний коронавируст халдварын тандалт, оношилгоо, эмчилгээ, халдвараас сэргийлэх арга хэмжээний заавар” 242 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, 2018 оны А/438 дугаар “Томуугийн цар тахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж”, 2019 оны “заавар батлах тухай” 537 дугаар тушаал, ДЭМБ-ын түр зөвлөмж болон энэхүү журмыг мөрдөж ажиллана.

Хоёр. Хамрах хүрээ

1. “Өлзийт 1 айдсын даваа” авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор тээврийн хэрэгслэлээр зорчиж байгаа бүх иргэдэд үзлэг тандалт хийгдэнэ.

Гурав. Удирдлага зохион байгуулалт

1. Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт, халдваргүйтгэл хийх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ажлыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Б.Лувсанням хариуцан ажиллах ба статистикч эмч З.Туяа, өрхийн менежер Г.Даваасүрэн нар нарийн бичгийн даргаар ажиллана.
2. “Өлзийт 1 айдсын даваа” авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд 24 цагийн үйл ажиллагааг эмч ахалж ажиллах бөгөөд мэдээ мэдээллийг өглөө бүрийн 09:00, орой 20:00 цагт Нийслэлийн засаг даргын Шуурхай штабын 11-324207 утсанд мэдээлнэ.
3. Эрүүл мэндийн төвийн даргын А/14 тоот тушаалын дагуу хариуцлагатай эргүүлээр удирдлагийн баг, эмч мэргэжилтнүүд хуваарийн дагуу ажиллаж доорхи үүргийг гүйцэтгэнэ.


- 3.1. Өглөө 09.00-11.00 цагт постон дээр ээлж хүлээлцүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хөдөлмөр аюулгүй байдлын журмыг танилцуулна.
 - 3.2. Постонд авч гарах эм тариа, хамгаалах хувцас хэрэгсэл ариутгал халдваргүйжүүлэх бодисын бэлэн байдлыг хангуулна.
 - 3.3. 13.00, 17.00, 22.00 цагуудад постон дээр ажиллаж буй эмч, сувилагчтай утсаар холбогдож постын үйл ажиллагаатай танилцаж шаардлагатай нэмэлт зүйлсийг бэлтгэж хүргэж өгнө.
 - 3.4. Орой 19.30, өглөө 7.30-д постын жижүүрээс мэдээ авч дотоод группд байршуулна.
 - 3.5. ХЭМТ, ХНЯТТ, ЭЭ, хүүхдийн жижүүр эмчийн үйл ажиллагаанд хяналт тавина.
 - 3.6. Хариуцлагатай эргүүл нь 24 цагаар ажиллана.
4. Товчоонд ажиллаж буй эмч эмнэлгийн мэргэжилтний унаа, хоолны зардал, илүү цагийн мөнгийг тооцож төсвийн зохих зардлаас олгоно.
 5. Тушаалаар томилогдсон хариуцлагатай жижүүрүүд болон эмч, сувилагч, асрагч бусад ажилтан нар нь дур мэдэн зөвшөөрөлгүй таслах, өөрчлөх, хийгээгүй, гар утсаа аваагүй эсвэл хаалттай тохиолдолд "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн дагуу сахилгын шийтгэл оногдуулахыг анхааруулсугай.

Дөрөв. Эмч эмнэлгийн мэргэжилтний үүрэг

1. Үзлэг эхлэхээс өмнө зорчигчдод шинэ коронавирусын халдварын сэжигтэй тохиолдлыг илрүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулан үнэн зөв мэдээллийг өгөх
2. Асуумжийн дагуу бүх зорчигчдоос сэжигтэй тохиолдлын мэдээлэл авна.
3. Тухайн тээврийн хэрэгслээр зорчиж буй иргэн бүрийн биеийн халууныг үзэх бөгөөд зайнаас хэмжигч халууны шилийг ашиглан зорчигчийн дух, чих эгэм орчинд хэмжинэ.
4. Сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар зорчигч "үгүй" гэсэн боловч 38 хэмээс дээш халуурсан шинж тэмдэг илэрвэл эмнэл зүйн хуудсыг бөглүүлэн 3-аас дээш асуултад "тийм" гэж харилусан бол гэрийн хаяг, холбоо барих утсыг тэмдэглэн авч, амны хаалт зүүлгэж, эмнэлэгт хандахыг зөвлөн нэвтрүүлнэ.
5. Сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар зорчигч "тийм" гэсэн боловч үзлэгээр халуунгүй, зовиургүй бол гэрийн хаяг, холбоо барих утсыг тэмдэглэн авч, 14 хоног өөрийгөө хянах, шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хандахыг зөвлөн нэвтрүүлнэ.
6. Сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар зорчигч "тийм" гэсэн болон 38 хэмээс дээш халуурсан шинж тэмдэг илэрвэл сэжигтэй гэж үнэлэн эмнэл зүйн асуумж бөглүүнэ. Ингэхэд 3-аас доош асуултад "тийм" гэж хариулсан бол амны хаалт зүүхийг зөвлөн, гэрийг хаяг, холбоо барих утсыг тэмдэглэн авч, 14 хоногт өөрийгөө хянаж, шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хандахыг зөвлөн нэвтрүүлнэ.

7. Хэрвээ тухай зорчигч халдвар гарсан орноор зорчсон, өвчтэй хүнтэй хамт байсан өгүүлэмжтэй ч түүнээс хойш 14-өөс дээш хоног өнгөрсөн бол түүнийг сэжигтэй тохиолдолд тооцохгүй.
8. Сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар зорчигч "тийм" гэсэн болон 38 хэмээс дээш халуурсан шинж тэмдэг илэрвэл сэжигтэй гэж үнэлэн эмнэл зүйн асуумж бөглүүлнэ. Ингэхэд 3-аас дээш асуултад "тийм" гэж хариулсан бол уг зорчигчид амны хаалт, бээлийн өмсүүлэн зорчигчдоос нэг метрийн зайд тусгаарлана.
9. Тухай зорчигчид нэг метрээс ойр байрлаж байсан хүмүүсийг хавьтал гэж үзэн мөн амны хаалт зүүлгэн эмнэл зүйн асуумжийг бөглүүлж гэрийг хаяг, холбоо барих утсыг тэмдэглэн авч, 14 хоног өөрийгөө хянах, шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хандахыг зөвлөн явуулна.
10. Сэжигтэй тохиолдол илэрсэн талаар ХӨСҮТ-ийн 80086829, ХӨСҮТ-ийн 70284393 дугаарын утаснуудад яаралтай мэдээлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авна.
11. Сэжигтэй зорчигч, хавьтлын мэдээллийг хүснэгтийн дагуу үнэ зөв, бодитойгоор тэмдэглэнэ.
12. Сэжигтэй зорчигчийн биеийн байдалд эрэмбэлэн ангилалт хийж, шаардлагатай тохиодолд яаралтай болон амилуулах суурь тусламжийг стандартын дагуу үзүүлж, яаралтай тусламжийн хуудсыг 2% хөтөлж, нэг хувийг шийлжүүлэн авч буй эрүүл мэндийн байгууллагын эмчид өгнө.
13. Сэжигтэй тохиодол гэж үзсэн зорчигчийг шилжүүлсний дараа тусгаарласан байр, хяналт шалгалтын цэгт эцсийн халваргүйжүүлэлтийг хлор агуулсан уусмалаар хийнэ.
14. Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх талаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг иргэд, тээврийн хэрэгслэлийн жолооч нарт тарааж, сурталчилна.
15. Хэрвээ сэжигтэй тохиолдлын талаар өмнө нь мэдээлэл авсан бол эрүүл мэндийн ажилтан хувийн хамгаалах хувцсыг бүрэн өмсөж тухайн тээврийн хэрэгсэлд орсон асуумж судлагааг аван үзлэг хийж, тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн Даргын
2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
11/16 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЗОРЧИГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУМЖ

1. Овог.....
2. Нэр.....
3. Хүйс Эр Эм /доогуур нь зурна уу/
4. Иргэншил.....
5. Регистрийн дугаар.....
6. Машины дугаар.....
7. Гэрийн хаяг.....
8. Утасны дугаар.....
9. Шаардлагатай үед холбоо барих хүний нэр, утасны дугаар
.....
10. Сүүлийн 14-21 хоногт зорчсон улс.....
11. Танд дараах шинж тэмдэг илэрч байвал + тэмдэг тавина уу?

№	Илэрсэн шинж тэмдэг	+	-	Илэрсэн шинж тэмдэг	+	-
1	38 ⁰ С-ээс дээш халуурах		8	Хэвлийгээр өвдөх		
2	Толгой өвдөх		9	Бөөлжих		
3	Булчингаар өвдөх		10	Суулгах		
4	Нүд улайх		11	Чичрэх		
5	Хоолой өвдөх		12	Арьсны тууралт		
6	Ханиалгах		13	Унтаа байдалд		
7	Хамраас нус гоожих		14	Бие сулрах		

12. Сүүлийн 14-21 хоногт халдварт өвчний сэжигтэй болон өвчтэй хүнтэй ойр байсан уу?
Тийм Үгүй /доогуур нь зурна уу/
13. Сүүлийн 7-14 хоногийн хугацаанд эм/антибиотик/ хэрэглэсэн үү?
Тийм Үгүй /доогуур нь зурна уу/
14. Мэдүүлэг авсан Он.....сар.....өдөр.....цаг.....минут.....
15. Зорчигчийн гарын үсэг.....

Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн Даргын
2020 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн
11/16 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**“ӨЛЗИЙТ 1 АЙДСЫН ДАВАА” АВТО ТЭЭВРИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ
ТОВЧООНД АЖИЛЛАХ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД ӨГӨХ
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

1. Өлзийт 1 айдсын даваа товчоонд ажиллахдаа үйл ажиллагаа эхлэхээс өмнө бэлтгэл ажлыг хангасан байна.

2. *Ажил эхлэхийн өмнөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа*

1.1 Тус үйл ажиллагааг тогтоосон байршилд үйл ажиллагаа явуулна.

1.2 Цаг агаарын байдалд тохируулан хувийн бэлтгэл ханган, дулаан хувцастай ирсэн байна.

1.3 Яаралтай тусламж үзүүлэх эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангасан байна. /Амбу, нэг удаагийн хэрэгсэл, тариур гэх мэт/

1.4 Эрүүл мэндийн сайдын 536, 537, 505 дугаар тушаалуудын хэрэгжилтийг ханган, халдварын хяналт, сэргийлэлтийн бэлэн байдлыг хангасан байна. /Хөдөлмөрийн хувцас, малгай, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, амын хаалт, аюулгүй хайрцаг, хар, шар уут, хогийн сав, нэг удаагийн бээлий, халдваргүйжүүлэх уусмал гэх мэт/. Мөн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад хурц үзүүртэй зүйлд хатгагдахаас сэргийлэх өртөлтийн цомгийг бэлтгэсэн байна.

1.5 Тусламж, үйлчилгээ үзүүлэх хэсгийн орц, гарц чөлөөтэй байх ба тусламж, үйлчилгээнд ашиглах ширээ, тавиур, тэргэнцэр, сандал, кушетка зэрэг нь тохиромжтой байрлагдсан эсэх, тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг тус тус шалгана.

1.6 Тусламж, үйлчилгээ үзүүлэх газарт очихдоо зориулалтын товлосон унаагаар очно.

3. *Ажил гүйцэтгэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа*

2.1 Тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлын хувцас болон хамгаалах хэрэгслэлийг бүрэн өмссөн байна. Үйлчүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ амны хаалт зүүж, 2 давхар бээлий өмсөнө. Бээлий болон гарыг спиртэн суурьтай уусмалаар халдваргүйжүүлнэ.

2.2 Тусламж, үйлчилгээ үзүүлж, эрэмбэлэн ангилахдаа эмчилгээ, оношилгооны стандарт, удирдамжийг мөрдөн, холбогдох анхан шатны маягтыг хөтөлнө.

2.3 Тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ халдварын хяналт, сэргийлэлтийг мөрдөн ажиллана.

2.4 Тусламж, үйлчилгээ үзүүлэх бүрт эмч, эмнэлгийн ажилтан гараа халдваргүйжүүлнэ.

- 2.5 Хэрэглэсэн эмнэлгийн тусгай хог хаягдлыг зориулалтын саванд ангилж, хийнэ.
- 2.6 Зүү, хурц үзүүртэй зүйлд хатгагдахаас сэргийлж, нэг гарын дүрэм баримтлан ажиллана.
- 2.7 Хурц, үзүүртэй зүйл хэрэглэсэн тохиолдолд аюулгүй хайрцагт хийнэ.

3. Тусламж, үйлчилгээний явцад эрсдэл үүссэн тохиолдолд авах аюулгүй ажиллагаа, арга хэмжээ

3.1 Хурц үзүүртэй зүйлд хатгагдсан тохиолдолд өртөлтийн цомгийг зааврын дагуу арга хэмжээ авна.

4. Ажил дуусах үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- 4.1 Ажил дууссаны дараа хамгаалах хувцасыг зааврын дагуу зөв тайлж, тусгай хог хаягдлын саванд хийнэ.
- 4.2 Эмнэлгийн тусгай хог хаягдлыг битүүмжлэн, зориулалтын унаагаар тээвэрлэн, заагдсан газарт эсвэл харьяа өөрийн эмнэлгийн тусгай хог хадгалах цэгт тушаана.
- 4.2 Хэрэглэсэн багаж, тоног төхөөрөмжийг зааврын дагуу халдваргүйжүүлнэ.
- 4.4 Тусламж, үйлчилгээ үзүүлээд буцахдаа зориулалтын товлосон унаагаар буцна.